

10th
ANNIVERSARY




BOGD BANK
JOINT STOCK COMPANY



ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2024



ИХ БОГД УУЛ Монгол улс, Баянхонгор аймаг



АГУУЛГА

1. БАНКНЫ ТУХАЙ

2. ХҮНИЙ НӨӨЦ

3. ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ


4. УРАМШУУЛАЛТ ХӨТӨЛБӨР

5. ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ


6. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БАНКНЫ ТУХАЙ

Богд Банк нь 2014 онд үүсгэн байгуулагдсанаасаа хойш орон даяар нийт 16 салбараар дамжуулж, харилцагч нартаа үйл ажиллагаа явуулж, улам өргөжин тэлсээр байгаа ба тэр дундаа жижиг, дунд бизнесийн зээл нь нийт зээлийн багцын талаас илүү хувийг бүрдүүлдэг ба худалдаа, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн салбарт бизнес эрхэлж буй эмэгтэйчүүдийг түлхүү дэмжиж байна. Мөн тус банк нь Монгол Улсын банкны реформын хүрээнд 2021 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгүүлж, олон нийтийн банк болсон анхны банк юм.



ХҮЙСИЙН ХАРЬЦАА



БАКАЛАВР




МАГИСТР



ДОКТОР

МОБАЙЛ БАНКААР ХАРИЛЦАГЧ БҮРТГЭХ ҮЙЛЧИЛГЭЭ




Банк нь харилцагчид санхүүгийн бүхий л үйлчилгээг өөрийн байгаа газраасаа авах боломжийг бүрдүүлэх үүднээс Банкны салбарт ирэлгүйгээр Богд Мобайл банкаар дамжуулан харилцагч болох боломжийг амжилттай нэвтрүүлэв.

“БОГД АГЕНТ ҮЙЛЧИЛГЭЭ”



Банк нь энэхүү үйлчилгээгээр дамжуулан харилцагчдад илүү ойртох, илүү түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор бидний хамтран ажилладаг томоохон байгууллага буюу төлөөлөгчийн газруудаар дамжуулан Богд банкны бүтээгдэхүүн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэв. Бид Богд Агент үйлчилгээгээ Богд Лизинг ХХК болон Бодьдаатгал ХК-тай хамтран хэрэгжүүлж байна.

ХҮНСНИЙ БОЛОН ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛ



Богд банк нь Засгийн газраас хэрэгжүүлж буй Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалтын зээлийг жилийн 6 хувийн хүүтэй, 48 сарын хугацаатай, Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн зээлийг жилийн 5 хувийн хүүтэй, 24-36 сарын хугацаатай олгож байна. Зээлийн дээд хэмжээг бизнесийн онцлог цар хүрээ болон зориулалттай уялдуулан тогтооно.

НООЛУУР БЭЛТГЭЛИЙН ЗЭЭЛ



Богд банк нь Засгийн газраас хэрэгжүүлж буй Ноолуур бэлтгэлийн зээлийг жилийн 5 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай, 1 зээлдэгдэгчид олгох зээлийн хэмжээ банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх нөхцөлтэй олгож байна.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫГ ДЭМЖИХ ЗЭЭЛ



Богд банк нь Засгийн газраас хэрэгжүүлж буй Аялал жуулчлалын салбарыг дэмжих зээлийг жилийн 11 хувийн хүүтэй, 24 сарын хугацаатай, 1 зээлдэгдэгчид олгох зээлийн хэмжээ 1.0 тэрбум хүртэл төгрөг байх нөхцөлтэй олгож байна.

ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗЭЭЛ



Иргэн, ААН нь эрхэлж байгаа бизнесийн үйл ажиллагааныхаа дагуу ашиглагдах үйлдвэрээс гарсан буюу цоо шинэ тоног төхөөрөмж, машин механизмыг Богд банктай хамтран ажиллах гэрээ байгуулсан бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авахад зориулан олгох бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлсэн. 500.0 сая төгрөг хүртэлх дүнтэй зээлийг 60 сарын хугацаатай, жилийн 22.8-28.8 хувийн хүүтэйгээр олгож байна.

ДУЛААЛГЫН ЗЭЭЛ



Эрчим хүчний 20%-ийн хэмнэлтийг бий болгох, хүлэмжийн хийн ялгарал, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор “Дулаан шийдэл” төслөөр Улаанбаатар хотын гэр хорооллын хувийн сууцандаа дулаалга хийлгэх үйл ажиллагааг санхүүжүүлэх дулаалгын зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлсэн. 50.0 сая төгрөг хүртэлх дүнтэй зээлийг 30 сарын хугацаатай, жилийн 22.8-25.2 хувийн хүүтэйгээр олгож байна.

ОРОН СУУЦНЫ УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН ЗЭЭЛ



Орон сууц худалдан авахад шаардлагатай урьдчилгаа төлбөрийг санхүүжүүлэх зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлж, 150.0 сая төгрөг хүртэлх дүнтэй зээлийг 240 сарын хугацаатай, жилийн 15.6-18.0 хувийн хүүтэй олгож байна.

ХОРШООНЫ ГИШҮҮН МАЛЧНЫ ЗЭЭЛ



Засгийн газраас хэрэгжүүлж буй Хоршооны гишүүн малчны зээлийг мал худалдан авах, малын хашаа, хороо, саравч худалдан авах, шинээр барих, МАА-д зориулагдсан барилга байгууламж барих, өргөтгөх, засварлах, тоног төхөөрөмж, дэд бүтцийг сайжруулах зэрэг хөрөнгө оруулалтын зориулалтаар олгож байна. Тус зээлийг 50.0 сая төгрөг хүртэлх дүнтэйгээр 60 сарын хугацаатай, жилийн 6.0 хувийн хүүтэйгээр олгож байна.

TAPATRIP 100% CASHBACK



Банк нь харилцагчийн өдөр тутмын амьдралын хэв маягтай уялдуулан TAPA TRIP-тэй хамтран харилцагчдад дугуй болон скүүтер унахдаа хэтэвчээ Богд банкны дансаараа цэнэглээд 100% нь буцаан олголт авах урамшууллыг хэрэгжүүлж байна.

ХҮҮХДИЙН ДАНСНЫ 10%-CASHBACK



Хүүхэд, багачуудыг хуримтлалтай болгох үүднээс “Хүүхдийн мөнгөн тэтгэмж”-ээ хүүхдийн хадгаламждаа хүлээн авсан тохиолдолд харилцагчид хүүхдийн мөнгөн тэтгэмжийн дүнгийн 10%-ийн буцаан олголтын урамшуулалт аяныг амжилттай хэрэгжүүлсэн.

КАРТЫН 3%-15% ХҮРТЭЛХ CASHBACK



Банк нь харилцагчийн төлбөрийн картын өдөр тутмын хэрэглээг дэмжих болон амьдралын хэв маягт тохируулан 3%-иас 15% хүртэлх буцаан олголтыг худалдаа, үйлчилгээний газартай хамтран хэрэгжүүлж байна.

ХҮҮХДИЙН ХАДГАЛАМЖИЙН УРАМШУУЛАЛ



Бид Хүүхдэд зориулсан “Итгэл” хүүхдийн хадгаламж эзэмшигчдэдээ зориулан хадгаламждаа орлого хийсэн хүүхдүүддээ Тоглоомын төвд тоглох эрхийн бичиг бэлэглэх урамшуулалт аяныг зарласан.

БИД ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХҮРЭЭНД 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ...

Богд банк болон Азийн хөгжлийн банк (АХБ) Монгол улсын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд ногоон зээлийг дэмжих зорилгоор 15 сая ам.долларыг санхүүжилт олгоход хамтарч ажиллахаар зээлийн гэрээнд гарын үсэг зурав.

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмэр оруулах үүднээс Монголын Ногоон Санхүүгийн Корпораци (МНСК) Европын Холбооны Свитч-Эшиа хөтөлбөрийн санхүүжилтээр 2022-2026 онд хэрэгжих “**Дулаан шийдэл**” төсөлтэй хамтран ажиллаж эхлэв.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний дэмжих сангаас 5 сарын 12-ны өдөр Монголбанк, Монголын банкны холбоо болон арилжааны банкуудтай хамтран Гачууртын Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэнд 14 га газарт **1000 гаруй модны тарьц суулгалаа.**



**ТЭРБУМ
МОДСАН**

ADB



Тos

МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ
САНХҮҮЖИЛТИЙН ХОЛБОО

БОГД БАНКНЫ 2024 ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ 15.01 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЛЭЭ

Богд банк 2024 эхний хагас жилийн татварын дараах цэвэр ашиг 15.01 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээ түвшинд хүрлээ. Тайлант хугацааны өөрийн хөрөнгийн өгөөж (annualized ROE) 21.52%, нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг (EPS) 12.0 төгрөгтэй хаагдлаа.

- Нийт хөрөнгө энэ оны хагас жилийн байдлаар 837.20 тэрбум төгрөгт хүрч өмнөх жилийн мөн үеэс 42.19%-аар өслөө.
- Цэвэр зээлийн багц оны эхнээс 47.37% өсөж 460.01 тэрбум төгрөгт хүрсэн.
- Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 3.5%-тай байна.
- Харилцагчын харилцах, хадгаламжийн эх үүсвэр оны эхнээс 18.81%-р өсөж 364.48 тэрбум төгрөгт хүрсэн байна.




БОГД БАНКНЫ 2024 ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ 15.01 ТЭРБУМ ТӨГРӨГТ ХҮРЛЭЭ

2024 онд олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас нийт 12.07 сая ам.долларын урт хугацаат эх үүсвэр шинээр татан төвлөрүүлж, жижиг дунд бизнесийг тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих, эрчим хүчний хэмнэлттэй үйл ажиллагаа болон хэрэглээг санхүүжүүлэхэд зориулахаар ажиллаж байна.

Тайлант хугацаанд Богд банк нь Банкны тухай хуулиар болон Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа. Үүнд:

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа 23.4% (байвал зохих хэмжээ 12.5%). Ийнхүү давуулан биелүүлсэн нөөц өөрийн хөрөнгө нь аливаа болзошгүй эрсдэлийг даахаас гадна ирээдүйд активын тэлэлт хийх, ногдол ашиг тараах боломжийг бий болгодог.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 32.2% (байвал зохих хэмжээ 25.0%) буюу бусдаас татан төвлөрүүлсэн нийт эх үүсвэрийнхээ 32.2% болох 204.72 тэрбум төгрөгийг бэлэн мөнгө болон бэлэн мөнгөнд түргэн хөрвөх боломжтой Монголбанкны Үнэт цаасанд байршуулан удирдаж байна.



БОГД БАНК ХК-ИЙН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
(мянган төгрөг)

№	Үзүүлэлт	Balance sheet items	2024.06.30
1	ХӨРӨНГӨ	ASSETS	
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	Cash and cash equivalents	173,962,784.1
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	Deposits and placements in banks and financial institutions	48,379,572.8
1.3	Хөрөнгө оруулалт	Financial investments	75,766,701.1
1.3.1	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	Investments in subsidiaries, associates and jointly controlled entities	0.0
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	Loans (net)	460,003,033.1
1.4.1	Хэвийн зээл	High grade	401,979,286.4
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	Standard	43,606,372.9
1.4.3	Чанаргүй зээл	Non-performing loan	16,426,591.8
1.4.4	Зээлийн хойшлогдсон төлбөр	Deferred loan payment	0.0
1.4.5	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	Accrued interest receivable on loans	5,143,003.4
1.4.6	Зээлийн эрсдэлийн сан	Provision for loan losses	(7,152,221.35)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	Derivatives financial assets	384,674.5
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	Other financial assets	25,933,852.0
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	Other non-financial assets	15,861,366.4
1.8	Үндсэн хөрөнгө	Fixed assets	8,112,643.2
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	Investment property	0.0
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	Assets held for sale	27,112,365.0
1.11	Биет бус хөрөнгө	Intangible assets	1,687,811.1
	Нийт хөрөнгийн дүн	Total assets	837,204,803.3

БОГД БАНК ХК-ИЙН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
(мянган төгрөг)

2	ӨР ТӨЛБӨР	LIABILITY	
2.1	Харилцах, хадгаламж	Current accounts & Deposits	364,485,749.4
2.2	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	Due to banks and financial institutions	237,477,118.0
2.3	Бусад эх үүсвэр	Other funding	74,343,253.4
2.4	Дериватив санхүүгийн өр төлбөр	Derivative financial liabilities	1,832,232.4
2.5	Бусад санхүүгийн өр төлбөр	Other financial liabilities	5,954,030.7
2.6	Бусад санхүүгийн бус өр төлбөр	Other non-financial liabilities	4,546,042.0
Нийт өр төлбөрийн дүн		Total liabilities	688,638,425.9
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	EQUITY	
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Share capital	100,000,000.0
3.2	Нэмж төлөгдсөн капитал	Share premium	(1,443,177.67)
3.3	Халаасны хувьцаа	Treasury shares	-5018255.1
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	Revaluation surplus	0.0
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	Retained earnings	53,955,665.28
3.6	Бусад өөрийн хөрөнгө	Other equity	1,072,144.96
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	Total equity	148,566,377.5
4	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	Total liabilities and equity	837,204,803.3

Тэнцлийн гадуурх данс	Off-balance sheet	
Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг (цэвэр дүнгээр)	Contingent liabilities and commitments	24,565,351.0

БОГД БАНК ХК-ИЙН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
(мянган төгрөг)

№	Орлого, зардлын зүйл	Income and expenses	2024.06.30
1	Хүүгийн орлого	Interest income	54,253,215.1
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	Deposit with the Bank of Mongolia	218,989.0
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	Deposits and placements in banks and financial institutions	946,309.1
1.3	Үнэт цаасны	Securities	10,343,066.4
1.4	Зээлийн	Loans	37,626,723.8
1.5	Бусад хүүгийн орлого	Other interest income	5,118,126.7
2	Хүүгийн зардал	Interest expense	32,153,545.7
2.1	Харилцахад төлсөн хүү	Interest paid in current accounts	97,556.5
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	Interest paid in deposit accounts	17,753,440.3
2.3	Зээлийн хүүгийн зардал	Loan interest expense	4,355,726.1
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	Securities interest expense	1,639,277.0
2.5	Бусад хүүгийн зардал	Other interest expense	8,307,545.7
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	Interest income (net) [(1)-(2)]	22,099,669.4
4	Эрсдэлийн сангийн зардал	Provision expense	4,536,106.0
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	Deposits and placements in banks and financial institutions	0.0
4.2	Үнэт цаасны	Securities	0.0
4.3	Зээлийн	Loans	4,536,106.0
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	Net interest income after provision [(3)-(4)]	17,563,563.5

БОГД БАНК ХК-ИЙН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
(мянган төгрөг)

6	Бусад орлого	Other income	12,983,597.6
6.1	Хүүгийн бус орлого	Non interest income	10,920,686.3
6.1.1	Арилжааны орлого	Trading income	2,521,011.6
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	Income on foreign currency exchange and revaluation	4,352,789.2
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	Fee and commissions income	2,471,682.5
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	Other non interest income	1,575,203.0
6.2	Бусад орлого, олз	Other income and gains	2,062,911.2
7	Бусад зардал	Other expense	14,585,490.4
7.1	Хүүгийн бус зардал	Other non interest expense	14,470,719.8
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	Other provision expense	0.0
7.1.2	Арилжааны зардал	Trading expense	206,850.9
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	Expense on foreign currency exchange and revaluation	4,837,825.4
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	Fee and commissions expense	550,818.1
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	Non operating other expenses	8,875,225.3
7.2	Бусад зардал, гарз	Other expenses and losses	114,770.7
8	Татварын өмнөх ашиг, алдагдал [(5+6-7)]	Profit before tax (5+6-7)	15,961,670.6
9	Орлогын татварын зардал	Income tax expense	950,465.8
10	Татварын дараах ашиг, алдагдал [(8-9)]	Profit after tax	15,011,204.8
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	Discontinued Operations net income, expense	0.0
12	Тайлант хугацааны нийт орлогын дүн [(10+11)]	Net profit for the current year (10+11)	15,011,204.8

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

2024.06.30

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Биелэлт
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>9%	23.40%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>12%	23.40%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	>25%	32.22%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа /нэгж валютаар/	<±15%	1.36%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа /нийт/	<±30%	1.51%

Банкны холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)	Активын хэлбэр	Үлдэгдэл дүн	Өөрийн хөрөнгөд эзлэх хувь
1 Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)			
1.1 Банкны хувьцаа эзэмшигч	Зээл, бусад	2.40	1.63%
1.2 Банкны эрх бүхий албан тушаалтан	Зээл, бусад	0.94	0.64%
1.3 Банкны бусад холбогдох этгээд	Зээл, бусад	6.84	4.64%
2 Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй)			
2.1 Банкны нийт хувьцаа эзэмшигч	Зээл, бусад	2.40	1.63%
2.2 Банкны эрх бүхий албан тушаалтнууд	Зээл, бусад	3.01	2.04%
2.3 Банкны бусад холбогдох этгээд	Зээл, бусад	13.28	8.97%



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

10th
ANNIVERSARY



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА

БОГД БАНК - ИТГЭЛ ТҮГЭЭНЭ